



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/1021

Мандалговь

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалт, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Нэг. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	О.Бат-Эрдэнэ (Засаг дарга)
Зөвлөлийн дэд дарга:	Ж.Мөнхчулуун (Засаг даргын орлогч)
Гишүүд:	Н.Эрдэнэ-Очир(ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
	С.Хулан (ЗДТГ-ын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн)
	Б.Мөнхчулуун (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга)
	Д.Удвалцэцэг (Үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүлэгч)
	Э.Азжаргал (Үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүлэгч)
	Ж.Зоригтбаатар (Ажил олгогч эздийн холбооны дарга)
	О.Саруул(Говийн бүсийн арга зүйн төвийн менежер)
	Б.Ням (МҮХАҮТ-ын Дундговь аймаг дахь салбар танхимын дарга)
Нарийн бичгийн дарга:	Э.Цэвэлмаа (ХХҮГ-ын хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга)

Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талуудын оролцоог ханган орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, дүрмийн дагуу ажиллахыг зөвлөлийн дэд дарга (Ж.Мөнхчулуун)-д үүрэг болгосугай.

Гурав. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 20-ний өдрийн А/65 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ 488190336